



**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.19 № 220

танай _____-ны № _____-т

**Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд
заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч иргэн ОЧИРБАТЫН ЭНХЗАЯА-ийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох "Монголын Хүний Төлөө Нам"-ын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817-1:2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-8:2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны

* 009020521

төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Бие даан нэр дэвшигч ОЧИРБАТЫН ЭНХЗАЯА-ийн орон нутгийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцохоор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрт тусгасан зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Очирбат овогтой Энхзаяагийн мөрийн хөтөлбөр (.....¹ хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Очирбат овогтой Энхзаяа-д

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР.....

Ш.МӨНХБАЯР/



АЙМАГ, СУМЫН ИТХ-ЫН 2024 ОНЫ 9 ДЭХ УДААГИЙН ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН 3
ДУГААР ТОЙРОГТ БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ ОЧИРБАТ ОВОГТОЙ ЭНХЗАЯАГИЙН
ДЭВШҮҮЛСЭН "ХАМТДАА БҮТЭЭЕ, ХӨГЖЬЕ" МӨРИЙН ХӨТӨЛБӨР
/2024-2028 он/

1. Гэр хорооллын айл өрхүүдийн усны хамгамжийг нэмэгдүүлэх талаар иргэдээс гарсан санал хүсэлтийг судлан шаардлагатай хэсэгт худаг байгуулах асуудлыг мэргэжлийн байгууллагаар дүгнэлт гаргуулан ИТХ-д танилцуулж хэрэгжилтийг бодлогоор дэмжин ажиллана.
2. Хоггүй баг хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэд, ААНБ-ын оролцоог нэмэгдүүлэхэд санаачлага гарган ажиллана.
3. Жишиг гудамж, Жишиг гэр хороолол бий болгох санаачлагыг өрнүүлж, ИТХ-д танилцуулж хэрэгжилтийг бодлогоор дэмжиж ажиллана.
4. Иргэдийн санал хүсэлтийн дагуу шаардлагатай байршилд сайжруулсан шороон зам барих ажлыг ИТХ-д танилцуулж, хэрэгжилтийг бодлогоор дэмжиж ажиллана.
5. Багийн нутаг дэвсгэрт гэрэлтүүлэг, камержуулалтын ажлыг үргэлжлүүлэн хийхийг бодлогоор дэмжинэ.
6. Нийтийн тээврийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, хүүхдийн автобусны үйлчилгээг өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
7. Багийн хөгжлийн төвийн орчин нөхцөлийг сайжруулах, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч бодлогын дэмжлэг үзүүлнэ.
8. Албан бус боловсролоор дамжуулан иргэдийн суралцах, хөгжих боломжийг бий болгоход бодлогын дэмжлэг үзүүлнэ.
9. Багийн нутаг дэвсгэрт дугуйн зам хийх ажлыг үргэлжлүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.
10. Байгалийн гамшиг тэр дундаа үер усны гамшигын эрсдэлийг бууруулахад анхаарч, гамшигын үнэлгээ хийлгэн үерийн далан хийх ажлыг бодлогоор дэмжиж ажиллана.
11. Ард иргэдийг соён гэгээрүүлэх чиглэл бүхий олон нийтийн ажлыг иргэдийн санаачлага дээр үндэслэн **ХТӨТөрийн 399 бус** байгууллага болон иргэдийн оролцоотойгоор зохион байгуулахад бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.
12. Багийн иргэдийн ая тухтай байдал, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэхэд зориулсан ногоон байгууламж бүхий бичил цэцэрлэгт хүрээлэнгийн орчинг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлж ажиллана.
13. Багийн иргэдэд үйлчилж буй хоол хүнс үйлдвэрлэл, үйлчилгээний газруудын эрүүл ахуй тэр дундаа сургууль, цэцэрлэгийн хүүхдийн хоолны орц, найрлага, шим тэжээлд хяналт тавьж, хүсний аюулгүй байдлыг бэхжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.
14. Багийн иргэдэд нийтийн биеийн тамираар хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд бодлогын дэмжлэг үзүүлнэ.
15. Багийн харъяалалтай ганц бие, өрх толгойлсон эх, эцэг, олон хүүхэдтэй, тогтмол орлогогүй болон орлого багатай өрх, иргэдийг дэмжих хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхийг ИТХ-д танилцуулж, бодлогын дэмжлэг үзүүлж ажиллана.

----- оОо -----